



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 138

Хөхөө

Бүх нийтийн хог цэвэрлэгээний
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн хог цэвэрлэгээг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсугай.

2.2024.05.10-ны өдөр өөрийн эзэмшлийн хашаа, орчныхоо хогийг бүрэн гүйцэд цэвэрлэсэн байхыг албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд үүрэг болгосугай

3.Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: З.Дашням – Хөхөө багийн Засаг дарга

Гишүүд: П.Оргил – Шивэрт багийн Засаг дарга

Н.Эрдэнэбаяр – Улаан-Асга багийн Засаг дарга

Ц.Гансүх - Хайрхан толгой багийн Засаг дарга

Г.Чулуунбаатар – Газрын даамал

П.Бямбасүрэн – Байгаль хамгаалагч

Б.Нямренчин – Байгаль хамгаалагч

Ц.Цэрэнчимэд – Эрүүл мэндийн төвийн дарга

Б.Өлзий – Цэцэрлэгийн эрхлэгч

Д.Оюунчимэг – Соёлын төвийн дарга

А.Отгонбаяр – Сургуулийн захирал

Нарийн бичгийн дарга: Б.Батжаргал – Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

670800100110

4. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах тусгай удирдамж, төлөвлөгөө, хуваарь гаргаж үр дүнтэй ажиллахыг ажлын хэсэг (З.Дашням)-д даалгасугай.

5. Уг ажлын хүрээнд сумын төвийн гудамж талбай, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэж, идэвхтэй оролцож ажиллахыг сумын нийт иргэд, албан газар, аж ахуй нэгж, байгууллага, дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Анхсанчир)-т даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХЖАРГАЛ